



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/АА1

Булган сум

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг
дэмжих тоног төхөөрөмжийг хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/192 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж (улсын хэмжээнд)" төсөл арга хэмжээний Багц-4 Булган аймгийн Хутаг-Өндөр сумын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж нийлүүлэх УТ2501900343004/06-478 дугаар гэрээний дагуу гүйцэтгэгч "Эй энд И инсуранси" ХХК-аас нийлүүлж байгаа 271,534,250 (хоёр зуун далан нэгэн сая таван зуун гучин дөрвөн мянга хоёр зуун тавь) төгрөгийн үнэ бүхий жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	Г.Гантулга (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга) Г.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн) Д.Уламбаяр (Орон нутгийн өмчийн газрын Бүртгэл ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Д.Мөнхбаасан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга)

2.Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмжийн иж бүрдлийг бүрэн бүтэн ашиглалтын бэлэн байдлыг хянаж, холбогдох барим бичгийг бүрдүүлж, техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээн авах, зохих журмын дагуу холбогдох байгууллагад шилжүүлэн өгөхийг ажлын хэсэг (Г.Гантулга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325011186